

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 22.1.10 дахь заалт нэмсүгэй:

“22.1.10.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн олгосон газар чөлөөлөлтийн нөхөх олговор, дэмжлэг”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 21.1.15 дахь заалт нэмсүгэй:

“22.1.15.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн олгосон газар чөлөөлөлтийн нөхөх олговор, дэмжлэг”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Наймдугаар бүлэгт дор дурдсан агуулгатай 8.10 дугаар зүйл нэмсүгэй:

"8.10 дугаар зүйл.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль тогтоомж зөрчих

1.Газрыг албадан чөлөөлөх үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулсан хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дор дурдсан агуулга бүхий 6.33 дахь заалт нэмсүгэй:

“6.33.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 8.10 дугаар зүйлд заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ